



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 75

Номгон

“Илгээлтийн эзэн” аймгийн дэд
хөтөлбөр батлах тухай

Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар бүлгийн 104 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Илгээлтийн эзэн” аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө гарган, жил бүрийн аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон төсөвт тусгаж үе шаттайгаар хэрэгжүүлж, хөтөлбөрийн явц, биелэлтийн талаар тухайн оны эцэст аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж байхыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

0117139

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 05 дугаар сарын
16-ны өдрийн 75 дугаар тогтоолын хавсралт



“ИЛГЭЭЛТИЙН ЭЗЭН” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

НЭГ. ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

Тус аймагт 2016 оны жилийн эцсийн тооллогоор 85331 хүн ам, үүнээс малтай өрхийн хүн ам 40580, малчид 22001 байна. 2011 оноос хойш 6 жилийн дунджаар малтай өрхийн тоо 1065-аар нэмэгдэж, хүн ам нь 7420 хүнээр буурч, малчин өрхийн тоо 410-аар, малчдын тоо 370 хүнээр нэмэгдсэн байна. Энэ нь малтай болох сонирхол эрмэлзэл ажилгүйчүүдийн дунд түгээмэл байгаа, цөөн малыг маллахад орлогын эх үүсвэр бага тул хөдөө гарч мал маллан малчин болох боломжгүй байна.

Мөн малчин өрх, хүн амын тоо сүүлийн 2 жилд өсөх хандлагатай байгаа хэдий ч 16-34 настай залуу малчдын тоо буурч, 35-аас тэтгэврийн насны ахмад малчдын тоо өсөх хандлагатай байна. Тухайлбал сүүлийн 6 жилийн дунджаар 16-34 насны залуу малчид 909 хүнээр цөөрсөн бол 35-аас дээш насны ахмад малчдын тоо 1012 хүнээр нэмэгдсэн байна. Иймд залуу малчдын тоо цөөрч байгаа хэдий ч мал аж ахуйн үйлдвэрлэлд гарч ажиллах иргэдийн хандлага сонирхол нэмэгдэж байгаа тул ажилгүй байгаа, буюу цөөн малтай өрхүүдийн малын тоо толгойг нэмэгдүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлж, малчдын залуу халааг бэлтгэх шаардлагатай байна.

Аймгийн хэмжээнд нийт 425 иргэн аж ахуйн нэгж, байгууллага газар тариалан эрхэлж аймгийн хүн амын хэрэгцээт төмсний 70.9%, хүнсний ногооны 38,4% хувийг орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр хангасан судалгаа байгаа ч хүнсний ногооны зах зээл дээр Хятад улсаас оруулж ирж буй төмс, хүнсний ногооны борлуулалтын хэмжээ 10-20 хувийг эзэлсээр байна. Бид экологийн цэвэр бүтээгдэхүүний тухай их ярьдаг болсон ч өдөр тутам хэрэглэж байгаа төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний дийлэнх хувийг гаднаас оруулж ирсэн импортын ногоо, бүтээгдэхүүн эзэлж байна.

Мөн аймгийн хэмжээнд нийт 3825,5 га газар тариалангийн боломжит талбай байгаагаас 1041,2 га талбайд тариалалт хийж, 822,6 га нь айл өрх, аж ахуйн нэгжийн эзэмшилд олгосон гэсэн дүн мэдээ байдаг. Тиймээс тариалангийн талбайгаа бүрэн эзэмшиж, ашиглан өрхийн хэрэглээний төмс хүнсний ногоогоо

тарьж ургуулан өрхийн орлогоо нэмэгдүүлэхийн зэрэгцээ экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж нөхцөлийг бүрдүүлэхэд ажиллах хүчнийг нэмэгдүүлэх шаардлагатай юм.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд ажиллагчдын тоог нэмэгдүүлэх, малчид, тариаланчдын залуу халааг бэлтгэх, өрхийн амьжиргааны эх үүсвэрийг дээшлүүлэхэд дэд хөтөлбөрийн зорилго оршино.

Хөтөлбөрийн зорилгыг дараах зорилтоор хэрэгжүүлнэ.

2.1.Шинээр гэр бүл болж байгаа, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд гарч ажиллаж байгаа малгүй болон мал цөөтэй иргэдийг малжуулах, тариалангийн газрыг хууль эрх зүйн хүрээнд олгох,

2.2.Төв суурин газрын ажилгүй иргэдийг мал аж ахуй, газар тариалангийн цаг үеийн ажил арга хэмжээнд оролцуулах,

2.3.Ерөнхий боловсролын 9, 12 дугаар анги төгсөөд мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлд гарч ажиллах сонирхолтой хүүхдүүд, малжуулах болон газар тариалан эрхлэх хөтөлбөрт хамрагдах иргэдийг сургаж дадлагажуулна.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөтөлбөрийг үйл ажиллагааг 2 үндсэн чиглэлээр хэрэгжүүлнэ.

3.1. Мал аж ахуйн чиглэлээр:

3.1.1 Улс, аймаг, сумын аварга малчин болохоор тодорхойлогдох, журмын болзол хангах боломжтой малчид жил бүр илгээлтийн эзэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор сум, багийн малын эргэлтийн санд хонин толгойд шилжүүлснээр сүүлийн 3 жилд 100-аас доошгүй малыг хандивласан байна.

3.1.2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон бусад эх үүсвэрээр жил бүр тодорхой тооны шинээр гэр бүл болж байгаа, цөөн малтай буюу малгүй иргэдийг хонин толгойд шилжүүлснээр 100 толгой малаар малжуулна.

3.1.3.Орон нутагт хэрэгжиж байгаа ОУ-ын төсөл хөтөлбөрийн байгууллагуудын шугамаар цөөн малтай иргэдийг малжуулах, малын хашаа хороотой болох, худаг уст цэг гаргаж өгөхөд дэмжлэг үзүүлнэ.

3.1.4.Улс, орон нутгийн санхүүжилтээр малын эргэлтийн сан бүрдүүлж ерөнхий боловсролын сургууль төгссөн болон цөөн малтай, ажилгүй байгаа мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллах хүсэл сонирхолтой иргэдийг малжуулж малчдын залуу халааг бэлтгэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.1.5 Төв суурин газрын ажил идэвхтэй хайгч иргэдийг хөдөө аж ахуйн салбарын цаг үеийн шинж чанартай /ямаа самнах, хонь хяргах, тэмээ ноослох, мал

төллүүлэх, сүү цагаан идээ боловсруулах, хадлан тэжээл бэлтгэх, хашаа хороо барих зэрэг/ нийтийг хамарсан ажил арга хэмжээнд зорилтот сангийн санхүүжилтээр тодорхой хугацаагаар хамруулна.

3.1.6. Мал аж ахуйн үйлдвэрлэлд гарч ажиллах иргэдэд уламжлалт мал маллагааны арга туршлага, бэлчээрийн менежментийн талаар сургалт явуулж, ахмад малчдад шавь оруулсан байна.

3.1.7. Малчдын залуу халаа бэлтгэх зорилгоор мал аж ахуйн үйлдвэрлэлд гарч ажиллах иргэдээс сонголт хийж малжуулах арга хэмжээнд хамруулах бөгөөд малчинд олгох стандартын шаардлага хангасан малыг сум, багийн комисс хүлээлгэн өгнө.

3.1.8. Олон малтай малчид санаачилгаараа зорилтот бүлэгт малжуулах арга хэмжээг хэрэгжүүлэхийг дэмжин хамтран ажиллана. Туслах малчин ажиллуулан малжуулж болох бөгөөд гэрээ байгуулан хэрэгжүүлнэ.

3.1.9. Сумын Засаг даргын тамгын газар нь мал аж ахуйн үйлдвэрлэлд гарч ажиллаж байгаа иргэдэд өвөлжөө, хаваржааны газрыг хууль тогтоомжийн дагуу эзэмшүүлж, малын хашаа хороо, усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх, малаас ашиглаж байгаа бүтээгдэхүүнийг борлуулахад энхний ээлжинд анхаарч дэмжлэг үзүүлэх,

3.2. Газар тариалангийн чиглэлээр:

3.2.1. Улс, аймаг, сумын аварга тариаланч болохоор тодорхойлогдох, журмын болзол хангах боломжтой тариаланч, ногоочид жил бүр 2-5 залуу тариаланчийг дэмжин тусалж гарааны бизнесийг эхлүүлсэн байна.

3.2.2. Бүлэг нөхөрлөлийн журмаар газар тариалан эрхэлж буй залуу тариаланчдыг дэмжин тусалж буй ААН байгууллагуудыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамруулах

3.2.3. Төсөл хөтөлбөрийн шугамаар газар тариалан эрхлэгчдийг техник тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээнд хамруулна.

3.2.4. Шинэчлэн засварлагдсан услалтын системүүдийг бүрэн ашиглах зорилгоор ерөнхий боловсролын сургууль төгссөн болон ажилгүй байгаа газар тариалан эрхэлж өрхийн орлогоо нэмэгдүүлэх хүсэл сонирхолтой иргэдийг тариалангийн газар олгох арга хэмжээнд хамруулна.

3.2.5. Газар тариалангийн цаг үеийн /хөрс боловсруулах, үр үрслэгээ бэлтгэх, тариалалт хийх, талбай бордох, халдваргүйжүүлэх, ургац хураах зэрэг/ ажилд халамжийн хөрөнгийн санхүүжилтээр нийтийг хамарсан ажилд хамруулах арга хэмжээ авах



3.2.6. Газар тариалангийн үйлдвэрлэлд гарч ажиллах иргэдэд таримлын үр үржүүлэг, сорт сорилт, үр, суулгацын чанар хангамжийг сайжруулах, хүнсний аюулгүй байдлыг хангах, тариалангийн арга туршлагын талаар сургалт явуулж, ахмад тариаланчдад шавь оруулсан байна.

3.2.7. Тариаланчдийн залуу халаа бэлтгэх зорилгоор шинээр газар эзэмшиж байгаа иргэдэд стандартын шаардлага хангасан сортын үрийг сумын комисс хүлээлгэн өгнө.

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА, ҮЕ ШАТ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4.1. Хөтөлбөрийг 2017-2020 онд хэрэгжүүлнэ.

Мал аж ахуйн салбарын хувьд 2017 оныг бэлтгэл хангах үе, 2018 оноос цөөн малтай малчдыг малжуулах үе, 2019 оноос малчдын залуу халааг бэлтгэх арга хэмжээг хэрэгжүүлж эхлэнэ. Малжуулах арга хэмжээг тухайн оны 06 дугаар сард өрх тус бүрийг төлтэй 50 үржлийн хээлтэгч малаар малжуулна.

Газар тариалангийн салбарын хувьд 2017 оноос тариалангийн талбайн тооллого судалгаа хийж, иргэдэд хууль, эрх зүйн хүрээнд тариалангийн газар ашиглуулах, 2018 оноос эзэмшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Бэлтгэл хангах үе шатанд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.1.1. Залуу малчид, тариаланчдад мал аж ахуй, газар тариалан эрхлэх талаар сургалт явуулна.

4.1.2. Илгээлтийн эзэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх сумын комиссыг томилж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батална.

4.1.3. Хөтөлбөрийг бүх малчин, тариаланч өрх, сонирхсон бусад хүмүүст хүргэж сурталчилах, шилдэг сум, баг, малчид, тариаланчдын туршлагыг танилцуулах,

4.1.4. Хөтөлбөр хэрэгжүүлэх журам гарган, шалгуур үзүүлэлтийг тогтоож, тооцоо судалгааг нарийвчлан хийнэ.

4.2. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтыг дараах байгууллага хариуцна.

4.2.1. Хөтөлбөрийг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах, зохицуулах үүргийг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон комисс,

4.2.2. Хөтөлбөрийг сумын хэмжээнд удирдан зохион байгуулах, зохицуулах үүргийг сумын Засаг дарга,

4.2.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг аймаг, сумын комисс боловсруулан, үр дүнг жил бүр тооцож ажиллана.

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

5.1. Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан,

5.2. Гадаад улс, олон улсын байгууллага, хандивлагчийн зээл тусламж,

5.3. Малчид, иргэдийн хандив тусламж,

5.4. Бусад

Баг бүр 2-оос доошгүй өрх малжуулахаар тухайн оны 10 дугаар сарын 10-ны дотор баг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар малжуулах өрхийн нэр, тоог шалгаруулан баталж, санхүүжилт авах хүсэлтээ аймгийн Засаг даргад ирүүлнэ. Аймгийн Засаг дарга хөтөлбөрийн үр дүн, малжуулалтад хамрагдах өрхийг судалсны үндсэн дээр тухайн сумын малжуулах хөрөнгийн хэмжээтэй адил хөрөнгөөр санхүүжүүлнэ. Малжуулах сонгон шалгаруулалтад тэнцсэн малчдыг малжуулах арга хэмжээний санхүүжилтийн 20%-ийг баг, 30%-ийг сум, 50%-ийг аймаг хариуцна.

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН

6.1. Мал сүргээ мал эмнэлгийн арга хэмжээнд бүрэн хамруулсан эрүүл сүрэгтэн малчдаас мал авч малжуулснаар малын халдварт өвчин гарахгүй байх нөхцөл бүрдэнэ.

6.2. Хэт цөөн малтай малчдын тоо цөөрч, амьжиргааны эх үүсвэр сайжирна.

6.3. Ажилгүй иргэдийн тоо цөөрнө.

6.4. Тариалсан талбайн хэмжээ өсөж, ургац нэмэгдэнэ.

6.5. Малын тэжээл бэлтгэлийн хэмжээ нэмэгдэнэ.

ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг 7.4-т тусгасан шалгуур үзүүлэлтийн дагуу аймгийн Засаг даргын Тамгын газар хийнэ.

7.2. Малын эргэлтийн сангаас өрх тус бүрийг хонин толгойд шилжүүлснээр 150-аас доошгүй толгой хээлтэгч малаар малжуулах бөгөөд тухайн малчинтай 5 жилийн гэрээ байгуулж, 3 дахь жилд 50%-ийг, 4 дэх жилд 50%-ийг нь эргүүлэн төвлөрүүлнэ.

7.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг сумын Засаг даргын Тамгын газар жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

7.4. Үр дүнгийн шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт	Хэмжих үзүүлэлт	2016 оны суурь түвшин	2020 оны түвшин
Малжуулах арга хэмжээнд хамрагдсан өрх, хүний тоо	Өрх хүн	224 853	250 1000
Малжуулах арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ	Мян.төг	597332,0	650000,0
Малжуулсан мал	тоо	10916	11000
Уламжлалт мал маллагааны арга туршлага эзэмшүүлэх сургалтад хамрагдсан залуу малчид	тоо	500	500
Газар тариалан эрхлэгч иргэд	тоо	425	550
Услалтын системүүдийн хүчин чадалд нь хүргэж ашиглалтын менежментийг сайжруулсан байх	га	180	300-400
Газар тариалангийн үйлдвэрлэлийн арга туршлага эзэмшүүлэх сургалтад хамрагдсан залуу тариаланчид	тоо	62	100-500
Нийтийг хамарсан арга хэмжээнд хамрагдсан иргэд	тоо	250	300
Малын эргэлтийн санд бүртгэгдсэн мал	Тоо	-	20000